



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2018 оны 12 сарын 06-ны
өдрийн 4057 дугаарт бүртгээ.

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/216

Улаанбаатар хот

Тамга, тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд
хяналт тавих, лавлагаа олгох журам
батлах тухай

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн
найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.11 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Тамга, тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох
журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Улсын бүртгэлийн
ерөнхий газар /Б.Баасандорж/-т, энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг
Төрийн нарийн бичгийн дарга /Г.Билгүүн/-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэ журам гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Хууль зүй,
дотоод хэргийн сайдын 2017 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн А/159 дүгээр
тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Ц.НЯМДОРЖ